# МОНГОЛБАНКНЫ МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ХУРААНГУЙ ТЭМДЭГЛЭЛ

№ 26/07 Улаанбаатар хот

Мөнгөний бодлогын хороо (МБХ) 2026 оны 11 дүгээр сарын 03-ны өдөр хуралдаж, хуралдааныг Монголбанкны Ерөнхийлөгч С.Наранцогт даргалав. Тус ээлжит хурлаар Монголбанкнаас макро эдийн засаг, банк, санхүүгийн салбарын өнөөгийн байдал, системийн эрсдэлийн шинжилгээний үр дүн, макро зохистой бодлогын арга хэмжээний талаар танилцуулга хийсэн бөгөөд МБХ-ны гишүүд холбогдох бодлогын шийдвэрүүдийг гаргав.

## 1. Макро эдийн засаг, банк санхүүгийн секторын талаар хийсэн танилцуулга

Эдийн засаг 2026 оны эхний 8 сарын байдлаар жилийн 7.3 хувиар өсөв. Экспортын түүхий эдийн үнэ болон биет хэмжээ төсөөллөөс өндөр байгаа тул 2026 оны эдийн засгийн өсөлт нэмэгдэх хүлээлттэй байна. Мах, махан бүтээгдэхүүн, үйлчилгээ, шатахууны үнийн өсөлтийн нөлөөгөөр жилийн инфляц энэ оны 9 дүгээр сард 12.9 хувьд хүрлээ. Инфляц богино хугацаанд дотоодын хүнс, шатахууны үнийн өсөлтийн нөлөөгөөр эрчимжиж 2027 оны 1 дүгээр улиралд оргил цэгтээ хүрч, цаашид алгуур саарахаар байна. Газрын тосны үнийн өсөлтийг даган импортын шатахууны үнэ нэмэгдэж байна. Нефтийн бүтээгдэхүүний импорт энэ оны эхний 9 сарын байдлаар жилийн 42 хувиар буюу 650 орчим сая ам.доллараар нэмэгдэв. Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого энэ оны 9 дүгээр сарын гүйцэтгэлээр 22.9 их наяд төгрөг, зарлага 24.6 их наяд төгрөгт хүрч, нийт тэнцвэржүүлсэн тэнцэл 1.6 их наяд төгрөгийн алдагдалтай гарсан байна. Мөнгөний нийлүүлэлтийн өсөлт гадаад цэвэр актив болон зээлийн өсөлтийн нөлөөгөөр эрчимжиж 30.7 хувьд хүрэв. Зээлийн өсөлт тогтворжих хүлээлттэй байгаа бөгөөд өсөлтийн дийлэнх хэсгийг бизнесийн зээл бүрдүүлж байна.

Санхүүгийн системийн мөчлөгийн эрсдэлийн нөхцөл байдлыг тодорхойлдог гол бүрэлдэхүүн үзүүлэлтүүд болох зээлийн өсөлт болон хөрөнгийн үнийн өсөлт саарч, санхүүгийн мөчлөг тэнцвэрт түвшин орчимд хүрсэн байна. Хөрөнгийн зах зээлийн хувьд орон сууцны үнийн өсөлт саарч, үнэ тогтворжих хандлагатай байна. Зээл болон ДНБ-ий харьцааны урт хугацааны трендээс зөрөх зөрүү буурч байгаа бөгөөд үүнд эдийн засгийн өсөлт эрчимжиж, зээлийн өсөлт саарсан нь нөлөөллөө.

Банкны салбарын зээл 2026 оны 9 дүгээр сард жилийн 15.4 хувиар өсөж, үүний 10.9 нэгж хувийг ААН-үүд болон иргэдийн ЖДҮ-ийн бизнесийн зээл, 3.0 нэгж хувийг хэрэглээний зээл, 1.6 нэгж хувийг ипотекийн зээл бүрдүүлэв. Бизнесийн зээл нь барилга, худалдаа, боловсруулах салбаруудад төвлөрч байгаа бол иргэдийн хэрэглээний зээлийн өсөлт өмнөх жилүүдтэй харьцуулахад саарсан нь Монголбанкнаас хэрэгжүүлж буй бодлогын арга хэмжээтэй холбоотой байна.

Банкны салбарын зээлийн чанар харьцангуй тогтвортой байгаа ч иргэдийн хэрэглээний зээлийн чанар муудаж байна. Энэ оны 9 дүгээр сарын байдлаар банкны салбарын

чанаргүй зээл 5.2 хувьд хүрч харьцангуй тогтвортой байгаа бол анхаарал хандуулах зээл 2.3 хувьд хүрч буурлаа.

Банкны хэрэглээний зээлийн өсөлтийг авч үзвэл, өр, орлогын харьцаа (ӨОХ)-ны хязгаарлалттай зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 5.0 хувиар буурч 8.5 их наяд төгрөгт хүрлээ. Харин тус хязгаарлалтад хамаарахгүй хэрэглээний зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 27.8 хувиар өсөж 5.2 их наяд төгрөгт хүрсэн ба үүнд тэтгэврийн зээлийн үлдэгдэл жилийн 42.3 хувиар өссөн нь голлон нөлөөлөв. Хэрэглээний зээлийн чанарыг авч үзвэл анхаарал хандуулах зээл 2.0 хувь, чанаргүй зээл 5.9 хувь байна. Хэрэглээний чанаргүй зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 35.1 хувиар өссөн бөгөөд үүний 29 нэгж хувийг цалингийн чанаргүй зээлийн өсөлт бүрдүүлэв. Банкны системийн чанаргүй зээлийн 31.6 хувийг хэрэглээний зээл бүрдүүлж байна.

Бизнесийн зээлийн жилийн өсөлт энэ оны 9 дүгээр сарын байдлаар 17.5 хувьд хүрч харьцангуй тогтвортой байна. Чанаргүй зээл 7 хувьд тогтвортой байгаа ч эдийн засгийн салбаруудаарх хувь нь харилцан адилгүй байна.

Банкны системийн төлбөрийн чадвар, хөрвөх чадвар, ханшийн эрсдэл болон төвлөрлийн харьцаа үзүүлэлтүүд зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг хангаж байна. Тодруулбал, системийн дундаж өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлт 15.3 хувь, хөшүүргийн харьцаа 8.6 хувь, төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа 43.3 хувь, нийт гадаад валютын позиц ба өөрийн хөрөнгийн харьцаа 5.4 хувь байна.

Монголбанкнаас авч хэрэгжүүлж буй бодлого, зохицуулалтын нөлөөгөөр банкнуудаас давхардуулан зээл авах байдал буурч байгаа ч банкны болон бусад санхүүгийн байгууллагаас давхардуулан авсан зээлийн үлдэгдлийн эзлэх хувь өндөр хэвээр байна. 2026 оны 9 дүгээр сарын байдлаар банкны зээлтэй 1.2 сая зээлдэгч иргэд байгаагаас 41.5 хувь нь банк болон банк бус санхүүгийн байгууллагаас давхар зээлтэй байна. Энэ нь санхүүгийн салбар хоорондын нийтлэг зээлдэгчээр дамжих зээлийн эрсдэл нэмэгдэж буйг илтгэж байна.

Системийн эрсдэлийн шинжилгээний хүрээнд хийсэн банкны салбарын төлбөрийн чадварын стресс тестийн үр дүнд макро эрсдэлийн хүчин зүйлсийн суурь төсөөллөөр банкнуудын ашигт ажиллагаа болон өөрийн хөрөнгийн хүрэлцээ нийт системийн хэмжээнд өмнөх оны үзүүлэлтийн орчимд буюу зохистой түвшинд хадгалагдахаар байна. Стресс хувилбарын хувьд банкнуудын ашигт ажиллагаа муудахаар байгаа ч өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлт системийн хувьд зохистой түвшинд байхаар байна. Гэхдээ гадаад орчны тодорхой бус байдал өндөр хэвээр байгаа энэ үед банкнуудын эрсдэл даах чадварыг тогтмол үнэлж, эрсдэлийн удирдлагыг сайжруулахад анхаарах нь зүйтэй байгааг онцлов.

## 2. Хэлэлцүүлсэн бодлогын санал ба Мөнгөний бодлогын хорооны гишүүдийн байр суурь

Хэрэглээний зээлийн өсөлт банкны салбар болон банк бус санхүүгийн байгууллага (ББСБ)-ын салбарт эрчимтэй саарч байна. Тухайлбал банкны салбарын хэрэглээний зээлийн жилийн өсөлт энэ оны 9 дүгээр сарын байдлаар өмнөх оны мөн үеийн 16.0

хувиас 5.2 хувьд хүрч саарав. Хэрэглээний зээлийн өсөлт нам түвшинд хүрч буурсан боловч өмнөх хугацаанд олгогдсон зээлийн үлдэгдлийн чанар муудаж болзошгүй байна.

Банкны салбарын ӨОХ-ны хязгаарлалтай хэрэглээний чанаргүй зээл 2026 оны 9 дүгээр сард 9.1 хувьд хүрч, үлдэгдэл нь өмнөх оны мөн үеэс 34.5 хувиар өсөж 777.5 тэрбум төгрөгт хүрлээ.

Иргэдийн бодит цалин энэ оны 2 дугаар улирлын байдлаар 1.0 хувиар өссөн бол өрхийн бодит хэрэглээ жилийн 4.9 хувиар буурлаа. Ийнхүү өрхийн бодит хэрэглээ цар тахлаас хойш анх удаа агшсан нь өрхийн эмзэг байдал нэмэгдэж буйг илтгэж байна. Түүнчлэн улсын хэмжээгээр нийт ажиллагсдын тоо 2026 оны 2 дугаар улиралд 1.6 хувиар буурав.

Энэ оны 9 дүгээр сарын байдлаар банкны зээлтэй зээлдэгчдийн 66.4 хувь нь 45 хувиас дээш ӨОХ-тай байна. Үүнд нэг талаас иргэд банк болон банк бус санхүүгийн салбараас давхар зээл авч, өрийн дарамтад орж байгаа нь нөлөөлж байна. Нөгөө талаас Монголбанк болон Санхүүгийн зохицуулах хорооны зохицуулалтын ялгаатай байдал нь иргэд олон байгууллагаас зэрэг зээл авах, улмаар өрийн дарамтаа нэмэгдүүлэх эрсдэлийг бий болгож байна.

Банкнууд “Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-ын дагуу зээлийн бүтцийн өөрчлөлт хийх боломжтой боловч цалин, малчны зээл, автомашины зээл зэрэг ӨОХ-ны болон хугацааны хязгаарлалт бүхий хэрэглээний зээлийн хувьд зээлийн хугацааг сунгах байдлаар бүтцийн өөрчлөлт хийхэд мөн эдгээр хязгаарлалтууд үйлчилдэг. Өөрөөр хэлбэл, хэрэглээний зээлд тогтоосон ӨОХ-ны 45 хувь болон хугацааны 30 сарын хязгаарлалтууд зээлийн хугацааг сунгах байдлаар бүтэц өөрчлөх зээлд мөн мөрдөгдөж байна. Гэвч дийлэнх зээлдэгчид хугацааны хязгаарлалтад тулгаж зээл авсан бөгөөд ӨОХ-ны үзүүлэлт нь 45 хувийг давсан байгаа тул зээлийн хугацааг сунгах байдлаар бүтцийг нь өөрчлөх орон зай хязгаарлагдмал байна.

Иймд санхүүгийн хүндрэлд орсон зээлдэгчдийн сарын төлбөрийн дарамтыг бууруулах, дээрх хязгаарлалтыг журамд заасан бүтцийн өөрчлөлтийн зохицуулалттай нийцүүлэх зорилгоор ӨОХ-ны хязгаарлалттай хэрэглээний зээлд нэмэлт зээл олгохгүйгээр хугацааг сунгах саналыг Монголбанкнаас МБХ-ны гишүүдэд танилцуулав. Санхүүгийн хүндрэлд орсон зээлдэгчийн зээлд бүтцийн өөрчлөлт хийх орон зайг нэмэгдүүлэх нь зээлдэгчийн санхүүгийн дарамтыг бууруулж, зээлээ үргэлжлүүлэн төлөх, төлбөрийн чадвараа сэргээхэд дэмжлэг үзүүлэх ач холбогдолтойг онцлов.

МБХ-ны гишүүдийн зүгээс бүтэц өөрчлөх хэрэглээний зээлийн хугацааг сунгаснаар иргэд банк болон бусад салбараас нэмэлт зээл авах орон зайг бий болох эсэх, ийм шийдвэр гарсан тохиолдолд тэтгэврийн зээл гэх мэт ӨОХ-ны хязгаарлалтгүй зээлийн өсөлтөд нөлөөлөх эсэх талаар тодруулсны сацуу ийм арга хэмжээ нь санхүүгийн сахилга батгүй зээлдэгчдийг дэмжиж, цаашид энэ төрлийн зээлдэгчдийг өөгшүүлж болзошгүй гэсэн болгоомжлолыг мөн илэрхийлэв.

Үүнд Монголбанкнаас зээлийн бүтцийг өөрчлөхөд зээлд нэмэлт санхүүжилт олгохгүй бөгөөд иргэдийн өрийн дарамт өндөр байгаа тул зээлийн эргэн төлөлтийг чухалчилж, зээл нэмэлтээр авах орон зай үүсэхгүй гэж үзэж байгаагаа илэрхийлэв. Тэтгэврийн

зээлийн хувьд ӨОХ-ны болон хугацааны хязгаарлалтгүй тул ийм шийдвэр гарлаа гэхэд тэтгэврийн зээлд нөлөөгүй ба хүндрэлд орсон тэтгэврийн зээлд банкнууд хязгаарлалтгүйгээр бүтцийн өөрчлөлт хийх боломжтой байгааг тайлбарлав.

МБХ-ны гишүүд банкны салбарын эрсдэл, өрхийн секторын нөхцөл байдлыг харгалзан ӨОХ-ны хязгаарлалттай хэрэглээний зээлд нэмэлт зээл олгохгүйгээр бүтцийн өөрчлөлт хийх нийт хугацааг 48 хүртэлх сараар тогтоох, тухайн зээлд ӨОХ-ны хязгаарлалт үйлчлэхгүй байх бодлогын саналыг дэмжив.

Монголбанкнаас төсвийн тодотгол, ирэх оны төсвийн төслийн дагуу иргэдийн цалин, орлого нэмэгдсэнээр хэрэглээний зээлд үзүүлэх нөлөө, өрхийн секторын нөхцөл байдлыг харгалзан хэрэглээний зээлийн ӨОХ-ны хязгаарлалтыг 40 хувь болгож чангаруулах, 50 хувьд хүргэж сулруулах бодлогын хувилбаруудын тооцооллыг танилцуулав. Чангаруулах хувилбараар иргэдийн зээлийн эрэлт ББСБ-ын салбар луу шилжиж, хүүгийн зардал нэмэгдсэнээр өрийн дарамт улам нэмэгдэх тооцоолол гарсан бол сулруулах хувилбарт банкны салбарын хэрэглээний зээлийн эрсдэл нэмэгдэх дүр зурагтай байлаа. Иймд өрхийн секторын нөхцөл байдал, макро, санхүүгийн орчны цаашдын төлөвийг харгалзан хэрэглээний зээлийн ӨОХ-ны дээд хязгаарыг 45 хувьд хэвээр хадгалж, бусад макро зохистой бодлогын арга хэрэгслүүдийн хувь хэмжээг хэвээр хадгалах саналыг дэвшүүлэв.

МБХ-ны гишүүдийн зүгээс макро санхүүгийн орчны төлөвийг харгалзан ӨОХ-ны дээд хязгаарыг 45 хувьд хэвээр хадгалах болон макро зохистой бодлогын бусад арга хэрэгслүүдийн хувь, хэмжээг хэвээр хадгалахыг санал нэгтэй дэмжив.

Монголбанкнаас цар тахал, гадаад сектор болон төлбөрийн тэнцэл муудсан үед авч хэрэгжүүлсэн гадаад валютын ЗБН-ийн хөнгөлөлттэй зохицуулалтуудыг эргэн харж, хөрөнгийн урсгал сайжирч гадаад валютын албан нөөц нэмэгдэж буй энэ үед хөнгөлөлтийг шат дараатайгаар цуцалж, ирээдүйд хэрэгжүүлэх бодлогын орон зай үүсгэх, банкны санхүүжилтийн бүтцийн гадаад хамаарлыг зохистой түвшинд хадгалах зорилгоор “Гадаад зах зээлээс бонд болон зээл хэлбэрээр 2027 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс хойш шинээр татсан 360 хоногоос 3 жил хүртэлх хугацаатай гадаад валютын эх үүсвэрийн 50 хувийг, 3 жил болон түүнээс дээш хугацаатай гадаад валютын эх үүсвэрийн 25 хувийг заавал байлгах нөөц тооцох эх үүсвэрт хамруулах” бодлогын саналыг МБХ-ны гишүүдээр хэлэлцүүлэв.

МБХ-ны гишүүд гадаад орчны тодорхой бус байдал өндөр байгаа бөгөөд гаалийн үйл ажиллагааны доголдол, шатахууны нийлүүлэлтийн хомсдолоос үүдэн экспортын орлого тасалдаж болзошгүй тул гадаад зах зээлээс татсан эх үүсвэрийг ЗБН тооцох суурьт хэсэгчлэн хамруулах Монголбанкны санал нь цаг хугацааны хувьд тохиромжгүй байгааг илэрхийлэв. Цаашлаад бодлогын арга хэмжээний хүрээнд нэмэлт тооцоолол хийж, саналыг дахин хэлэлцэх нь зүйтэй гэж шийдвэрлэв.

## 3. Мөнгөний бодлогын хорооны шийдвэр ба санал хураасан байдал

МБХ-ны 2026 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн ээлжит хурлаар ӨОХ-ны хязгаарлалтад хамаарах хэрэглээний зээлд нэмэлт зээл олгохгүйгээр бүтцийн өөрчлөлт хийх тохиолдолд зээлийн хугацааг нийт 48 хүртэлх сараар сунгаж, тухайн зээлд ӨОХ-ны хязгаарлалт үйлчлэхгүй байхаар холбогдох зохицуулалтад өөрчлөлт оруулах, ӨОХ-ны дээд хязгаарыг 45 хувьд хэвээр хадгалах шийдвэр гаргав. Тус шийдвэр 2026 оны 11 дүгээр сарын 04-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөхөөр болов. Бодлогын саналын шийдвэр:







